

“Эрүүл мэндийн салбарын шинэчлэлд бидний оролцоо”

Аймгийн зөвлөгөөний зөвлөмж /төсөл/

Улаангом

2016.01.14

1. Аймгийн эрүүл мэндийн хөгжлийн 2016-2020 оны стратеги боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх.
2. Эрүүл мэндийн салбарт жил бүр 2 тэрбумаас доошгүй төгрөгийн хөрөнгө оруулалтыг улс орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрийг дайчлан хийж, үйлчилгээний таатай орчинг сайжруулах.
3. “Ээлтэй эмнэлэг” аяныг өрнүүлж жилд 5-аас доошгүй хамт олныг өрх, сум, сум дундын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгийн тасаг, хувийн хэвшлийн эмнэлэгүүдээс шалгаруулан тус бүрд 10 саяас доошгүй төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмж олгон урамшуулах.
4. Зорилтот бүлэгт чиглэсэн “Амны хөндийн эрүүл мэнд”, “Чихэр, давс, хийжүүлсэн ундааны зохисгүй хэрэглээг бууруулах”, “Хүүхэд бүрт сүү”, “Нөхөн үржихүйн загвар эмнэлэг” төсөл, “Эрт илрүүлэг” зэрэг хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр дүнд хүрэх.
5. Ээлтэй эмч, ажилтан, шалгаруулах “Аймгийн Засаг даргын нэрэмжит шагнал”-ыг бий болгож, жил бүрийн тэмдэглэлт өдрөөр тус бүр 10-аас доошгүй хүнийг шалгаруулан 1 саяас доошгүй мөнгөн шагналаар шагнаж алдаршуулах.
6. Эрүүл мэндийн салбарт ажиллагсдаас ажлын үр дүн амжилтыг үнэлэн жил бүр 100-аас доошгүй хүнийг “Сайн туршлага-Шинэ санаа” гадаад арга хэмжээ аялалд оролцуулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх.
7. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг цусны ерөнхий шинжилгээний анализатороор хангах.
8. Аймгийн нэгдсэн эмнэлгийг гемодиализын аппарат болон эмэгтэйчүүдийн хэвлийн хөндийн дурангийн хагалгааны багаж, тоног төхөөрөмжөөр хангах.
9. Сум, сум дундын, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг цахим эмнэлэг болгож, үйлчилгээг хөнгөн шуурхай байх, хүлээгдэх, чирэгдлийг арилгах.
10. Аймгийн эрүүл мэндийн салбар нэгж бүрт чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

Зөвлөгөөнд оролцогчид